



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.01.08

№

1/33

танай _____-ны № _____-т

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА
Э.ТҮВШИНЧУЛУУН ТАНАА**

Танаас ирүүлсэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны "Тариф батлах тухай" 668 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн..... дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.



Х.НЯМБААТАР

151600028

A5 Файл.2022



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 01 сарын 03-ны
өдрийн 6098 дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 668

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Налайхын дулааны станц” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Налайхын дулааны станц” ТӨХК (Ц.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.БолорЭрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 234 дүгээр тогтоол, 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 381 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ




Э.ТҮВШИНЧУЛУУН

П.ТОВУУДОРЖ


Л.ДАШМЯГМАРЖАВ

Э.САМДАН

Ц.НОРОВЖАМЦ



Эрчим хүчний зохицуулах хорооны
2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
668 дугаар тогтоолын хавсралт



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	1,100
		Төг/Гж	33,041
2	Төсвийн байгууллагын халаалт	Төг/м ³	1,651
		Төг/Гж	33,041
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	6,930
		Төг/м ³	6,912

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал		Хэмжих нэгж	Тариф	
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м ²	600	
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	2,875
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	4,025
		Усны зарцуулалтаар		Төг/м ³	5,000
3	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
3.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх		Төг/сар	3,000	
3.2	40 м ² -аас 80 м ² талбайтай айл өрх		Төг/сар	5,000	
3.3	80 м ² -аас дээш талбайтай айл өрх		Төг/сар	10,000	

